



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2022/62/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Архангай аймаг Ихтамир сум 2022 он</p>	<p>Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас:7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatar@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Монголиан бизнес рейтинг аудит ХХК Утас: 70005329 Цахим хаяг:mbr.audit.llc@gmail.com</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

65130 Цэцэрлэг, Архангай аймаг
Утас/Факс: 976-70333141
И-мэйл: arkhangai@audit.gov.mn

АРХАНГАЙ АЙМГИЙН ИХТАМИР
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Э.ЦЭРЭННАДМИД
ТАНАА

ᠲᠡᠭᠡᠨᠠᠢ ᠒᠒᠔ № ᠖᠑
танай _____ -ны № _____ -т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

A red rectangular official stamp is placed over the signature. The stamp contains Mongolian text, including the name 'Т.Байгалмаа' (T. Baygalmaa) and the title 'Аудитор' (Auditor). The signature 'Т. Байгалмаа' is written in black ink over the stamp.

Т.БАЙГАЛМАА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	107,245,151.88	114,069,145.88
35	БАРАА МАТЕРИАЛ	107,245,151.88	114,069,145.88
351	Түүхий эд материал	64,494,773.88	73,256,867.88
35110	Тусгай зориулалттай материал	63,777,492.88	70,722,892.88
35130	Эм боох материал	717,281.00	2,533,975.00
354	Хангамжийн материал	38,720,378.00	37,057,278.00
35410	Бичиг хэргийн материал	7,813,848.00	8,519,008.00
35420	Аж ахуйн материал	22,791,180.00	22,711,230.00
35440	Түлш, шатах тослох материал	6,999,850.00	4,999,800.00
35450	Барилгын засварын материал	1,115,500.00	342,000.00
35460	Хүнсний материал	-	485,240.00
35600	Мал амьтад	4,030,000.00	3,755,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,511,669,372.23	2,817,029,375.27
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,511,669,372.23	2,817,029,375.27
392	Биет хөрөнгө	2,454,378,622.23	2,759,807,375.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,440,161,884.66	2,663,100,885.66
39202	Хуримтлагдсан элэгдэл	(158,286,828.36)	(237,024,460.32)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,035,961.47	303,144,714.32
39206	Хуримтлагдсан элэгдэл	(205,663,207.28)	(220,821,786.66)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	113,457,875.89	113,008,895.75
39208	Хуримтлагдсан элэгдэл	(71,272,062.95)	(78,424,631.89)
39214	Бусад үндсэн хөрөнгө	44,131,141.00	211,176,023.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(9,045,932.57)	(14,940,666.16)
39217	Ном	18,859,790.37	20,588,401.57
393	Биет бус хөрөнгө	57,290,750.00	57,222,000.00
39301	Программ хангамж	300,000.00	300,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(231,250.00)	(300,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	57,222,000.00	57,222,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,618,914,524.11	2,931,098,521.15
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,618,914,524.11	2,931,098,521.15
51	Засгийн газрын хувь оролцоо	2,618,914,524.11	2,931,098,521.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	802,145,988.22	802,145,988.22
51101	Өмч: - төрийн	802,145,988.22	802,145,988.22
512	Хуримтлагдсан үр дүн	68,164,600.61	380,687,857.10
51210	Өмнөх үеийн үр дүн	68,164,600.61	68,503,860.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	312,183,997.04
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,748,603,935.28	1,748,264,675.83
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,618,914,524.11	2,931,098,521.15

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,309,214,450.54	1,622,926,674.33
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	105,569,450.54	32,184,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	105,569,450.54	32,184,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	105,569,450.54	32,184,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,316,075.00	32,184,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	71,253,375.54	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого – Үндсэн хөрөнгө		409,333,538.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,645,000.00	1,163,234,085.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,109,424,600.00	1,091,435,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,109,424,600.00	1,091,435,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,173,100.00	12,126,285.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,835,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,173,100.00	3,290,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,047,300.00	59,672,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,047,300.00	59,672,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,336,874,648.95	1,310,327,754.01
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,336,874,648.95	1,310,327,754.01
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,275,798,547.95	1,278,625,964.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,180,362.00	856,245,400.00
210101	Үндсэн цалин	533,538,698.00	554,273,036.00
210102	Нэмэгдэл	237,186,557.00	229,306,494.00
210104	Урамшуулал	82,455,107.00	72,665,870.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,460,184.00	114,661,000.00
210201	Тэтгэврийн даатгал	77,332,684.00	80,843,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,781,900.00	8,454,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,825,500.00	6,763,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,956,400.00	1,690,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,563,700.00	16,908,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	96,565,438.00	94,069,647.00
210301	Гэрэл, цахилгаан	12,554,765.00	12,642,177.00
210302	Түлш, халаалт	84,010,673.00	79,822,510.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,604,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	17,114,320.00	21,495,935.45
210401	Бичиг хэрэг	3,223,700.00	1,648,525.45
210402	Тээвэр, шатахуун	3,391,070.00	3,700,460.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	914,200.00	861,400.00
210404	Ном, хэвлэл	3,307,800.00	3,657,000.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	369,200.00	855,600.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,158,350.00	5,967,950.00
210408	Бараа материал акталсны зардал	2,750,000.00	4,805,000.00
2105	Нормативт зардал	40,171,434.00	58,146,829.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,992,514.00	12,064,756.00
210502	Хоол, хүнс	35,272,670.00	37,848,070.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,906,250.00	8,234,003.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,174,710.00	1,254,100.00
210604	Урсгал засвар	12,174,710.00	1,254,100.00
2107	Томилолт, зочны зардал	90,000.00	-
210702	Дотоод албан томилолт	90,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,188,780.00	5,468,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,408,580.00	4,668,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	780,200.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	135,853,319.95	127,284,952.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,838,090.00	6,356,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130,015,229.95	120,928,612.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,076,101.00	31,701,790.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,888,456.00	28,079,026.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	17,020,456.00	25,620,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,868,000.00	2,459,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,187,645.00	3,622,764.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,187,645.00	3,622,764.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(27,660,198.41)	312,598,920.32
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,922,465.03	414,923.28
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,922,465.03	414,923.28
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(2,922,465.03)	(414,923.28)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(30,582,663.44)	312,183,997.04

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,237,961,075.00</u>	<u>1,195,418,885.45</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,316,075.00	32,184,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	34,316,075.00	32,184,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,316,075.00	32,184,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	34,316,075.00	32,184,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,203,645,000.00	1,163,234,085.45
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,109,424,600.00	1,091,435,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,109,424,600.00	1,091,435,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,173,100.00	12,126,285.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	8,835,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,173,100.00	3,290,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	91,047,300.00	59,672,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	91,047,300.00	59,672,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,220,067,995.00</u>	<u>1,178,048,885.45</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,220,067,995.00	1,178,048,885.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,159,015,894.00	1,146,347,095.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,180,362.00	856,245,400.00
210101	Үндсэн цалин	533,538,698.00	554,273,036.00
210102	Нэмэгдэл	237,186,557.00	229,306,494.00
210104	Урамшуулал	82,455,107.00	72,665,870.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	116,460,184.00	114,661,000.00
210201	Тэтгэврийн даатгал	77,332,684.00	80,843,300.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,781,900.00	8,454,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,825,500.00	6,763,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,956,400.00	1,690,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,563,700.00	16,908,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	103,049,988.00	91,795,100.00
210301	Гэрэл, цахилгаан	12,554,765.00	12,642,177.00
210302	Түлш, халаалт	90,495,223.00	77,547,963.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,604,960.00
2104	Хангамж, бараа материалын зардал	11,174,340.00	12,759,185.45
210401	Бичиг хэрэг	921,100.00	1,643,985.45
210402	Тээвэр, шатахуун	3,391,340.00	3,700,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	897,100.00	861,400.00
210404	Ном, хэвлэл	3,684,500.00	3,657,200.00

Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	369,200.00	856,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,911,100.00	2,040,200.00
2105	Нормативт зардал	41,821,970.00	57,271,810.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,576,700.00	12,380,500.00
210502	Хоол, хүнс	35,272,670.00	38,333,310.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,972,600.00	6,558,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,609,450.00	100,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	100,000.00
210604	Урсгал засвар	13,609,450.00	-
2107	Томилолт, зочны зардал	90,000.00	-
210702	Дотоод албан томилолт	90,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,838,780.00	6,797,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,058,580.00	5,997,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	780,200.00	800,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,790,820.00	6,717,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,790,820.00	6,717,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	61,052,101.00	31,701,790.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	20,864,456.00	28,079,026.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	16,996,456.00	25,620,026.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,868,000.00	2,459,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	40,187,645.00	3,622,764.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	40,187,645.00	3,622,764.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>17,893,080.00</u>	<u>17,370,000.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	17,893,080.00	17,370,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	17,893,080.00	17,370,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	17,893,080.00	17,370,000.00
223001	Бусад хөрөнгө	17,893,080.00	17,370,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(17,893,080.00)</u>	<u>(17,370,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	802,145,988.22	1,748,603,935.28	68,164,600.61	2,618,914,524.11
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	339,259.45	339,259.45
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	802,145,988.22	1,748,603,935.28	68,503,860.06	2,619,253,783.56
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(339,259.45)	-	(339,259.45)
Тайлант үеийн үр дүн	-	-	312,183,997.04	312,183,997.04
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	802,145,988.22	1,748,264,675.83	380,687,857.10	2,931,098,521.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,183,230,600.00	1,179,669,836.00	(3,560,764.00)	99.7%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,183,230,600.00	1,179,669,836.00	(3,560,764.00)	99.7%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,154,492,500.00	1,151,590,810.00	(2,901,690.00)	99.7%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	856,245,400.00	856,245,400.00	-	100.0%
210101	Үндсэн цалин	622,741,000.00	554,273,036.00	(68,467,964.00)	89.0%
210102	Нэмэгдэл	155,649,400.00	229,306,494.00	73,657,094.00	147.3%
210104	Урамшуулал	77,855,000.00	72,665,870.00	(5,189,130.00)	93.3%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	114,661,000.00	114,661,000.00	-	100.0%
210201	Тэтгэврийн даатгал	81,629,600.00	80,843,300.00	(786,300.00)	99.0%
210202	Тэтгэмжийн даатгал	8,257,900.00	8,454,500.00	196,600.00	102.4%
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,606,300.00	6,763,600.00	157,300.00	102.4%
210204	Ажилгүйдлийн даатгал	1,651,500.00	1,690,800.00	39,300.00	102.4%
210205	Эрүүл мэндийн даатгал	16,515,700.00	16,908,800.00	393,100.00	102.4%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,795,100.00	91,795,100.00	-	100.0%
210301	Гэрэл, цахилгаан	12,476,800.00	12,642,177.00	165,377.00	101.3%
210302	Түлш, халаалт	71,718,300.00	77,547,963.00	5,829,663.00	108.1%
210303	Цэвэр, бохир ус	7,600,000.00	1,604,960.00	(5,995,040.00)	21.1%
2104	Хангамж, бараа материалын зардал	8,632,900.00	8,632,900.00	-	100.0%
210401	Бичиг хэрэг	1,288,500.00	1,288,500.00	-	100.0%
210402	Тээвэр, шатахуун	3,700,000.00	3,700,000.00	-	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	861,400.00	861,400.00	-	100.0%
210404	Ном, хэвлэл	366,700.00	366,700.00	-	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	376,100.00	376,100.00	-	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,040,200.00	2,040,200.00	-	100.0%
2105	Нормативт зардал	60,353,500.00	57,451,810.00	(2,901,690.00)	95.2%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,560,500.00	12,560,500.00	-	100.0%
210502	Хоол, хүнс	41,235,000.00	38,333,310.00	(2,901,690.00)	93.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,558,000.00	6,558,000.00	-	100.0%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,500,000.00	8,500,000.00	-	100.0%
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,500,000.00	8,500,000.00	-	100.0%

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,797,200.00	6,797,200.00	-	100.0%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,997,200.00	5,997,200.00	-	100.0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	800,000.00	-	100.0%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,507,400.00	7,507,400.00	-	100.0%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,507,400.00	7,507,400.00	-	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,738,100.00	28,079,026.00	(659,074.00)	97.7%
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,738,100.00	28,079,026.00	(659,074.00)	97.7%
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	26,279,100.00	25,620,026.00	(659,074.00)	97.5%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,459,000.00	2,459,000.00	-	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,183,230,600.00	1,179,669,836.00	(3,560,764.00)	99.7%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,091,435,500.00	1,087,812,736.00	(3,622,764.00)	99.7%
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,091,435,500.00	1,087,812,736.00	(3,622,764.00)	99.7%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,672,300.00	59,672,300.00	-	100.0%
132001	Орон нутгийн төсвөөс	59,672,300.00	59,672,300.00	-	100.0%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	32,122,800.00	32,184,800.00	62,000.00	100.2%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	32,122,800.00	32,184,800.00	62,000.00	100.2%
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0%
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	79	79	-	100.0%
620001	Удирдах ажилтан	3	3	-	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	44	44	-	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	32	32	-	100.0%
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	644	644	-	100.0%
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД	644	644	-	100.0%
630001	Төрийн өмчит ЕБС	644	644	-	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,126,285.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,126,285.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,126,285.45
2104	Хангамж, бараа материалын зардал	4,126,285.45
210401	Бичиг хэрэг	355,485.45
210404	Ном, хэвлэл	3,290,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,000,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	12,126,285.45
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,126,285.45
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	8,835,785.45
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,290,500.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй, дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаатай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Солонготуяа, аудитор А.Жамъян нар гүйцэтгэж, үе шатны хяналтыг аудитын менежер Н.Алтанзул, Архангай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Д.Нэргүйбаатар, дарга, тэргүүлэх аудитор Т.Байгалмаа нар тус тус хэрэгжүүлсэн.

Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Монголиан Бизнес Рейтинг Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Архангай аймгийн Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Сурагч нэг бүрийн хөгжил, төлөвшилд ахиц гаргах Ажлын хариуцлага , ёс зүй, хууль дүрмийг хэрэгжүүлэх" гэж тодорхойлжээ.

Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Сургууль хүний хөгжлийн төв байх;
- Ажлын хариуцлага ёс зүйг дээшлүүлж хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Ажлын хариуцлага ёс зүй хууль дүрмийг хэрэгжүүлэх;
- Үйл ажиллагааны менежментийн хамгийн оновчтой хувилбарыг цогцлоон хөгжүүлэх;
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаа;
- Сургалтын чанар үр дүнг дээшлүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Сангийн сайдын 2021 оны 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”
- Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйл. “Нийгмийн даатгалын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн хүснэгтийн

Тэтгэврийн даатгал-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Тэтгэврийн даатгал-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "9.5" гэснийг "8.5" гэж, Шимтгэлийн дүн-Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.7" гэснийг "11.7" гэж, Шимтгэлийн дүн-Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос төлөх шимтгэлийн хувь хэмжээ /хувиар/ гэсний "12.5" гэснийг "11.5" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн "12.5 хувиас" гэснийг "11.5 хувиас" гэж тус тус өөрчилсүгэй”

- Монгол Улсын Засгийн газрын 2021 онд баталсан Үдийн хоолны норматив тогтоох тухай 237 дугаар тогтоолын 1-д “Ерөнхий боловсролын сургуулийн 1-5 дугаар ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2021 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 1500 төгрөг”, 2-д “...6-9 дүгээр ангийн нэг хүүхдэд ногдох үдийн хоолны зардлын нормативыг 2022 оны 9-р сарын 1-ний өдрөөс 1800 төгрөг”-өөр тогтоосугай гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн ба байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллага дотоод хяналтын журам, заавар боловсруулж, баталгаажуулаагүй байна.

Дотоод хяналтын комисс нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, хяналт хийж, тайланг захирлын зөвлөлд танилцуулж шийдвэрлүүлдэг ба төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналыг баримтжуулсан байна. Харин дотоод хяналтыг зөвхөн сургалтын үйл ажиллагаа, анги танхимын эрүүл ахуй, хүүхдийн эрүүл мэнд, хоол үйлдвэрлэлийн эрүүл ахуйн шаардлагын хүрээнд хийж, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,336.9 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 13.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10.7 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ихтамир сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 312.2 сая төгрөгөөр буюу 10.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

. Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	107.2	114.1	6.8
Биет хөрөнгө	2,454.4	2,759.8	305.4
Биет бус хөрөнгө	57.3	57.2	(0.1)
Нийт хөрөнгө	2,618.9	2,931.1	(312.2)
Хуримтлагдсан үр дүн	68.2	380.7	312.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,618.9	2,931.1	(312.2)

3.5.1. Бараа материалын дансны үлдэгдэл 114.1 сая төгрөг болж 6.8 сая төгрөгөөр өссөн байна. Тусгай зориулалтын материал 6.9 сая төгрөгөөр, эм боох материал 1.8 сая төгрөгөөр, тус тус өссөн нь нөлөөлсөн байна. Оны эцэст их хэмжээний худалдан авалт хийж бараа материалын нөөц үүссэн асуудал байхгүй байна.

3.5.2. Биет хөрөнгө дансны үлдэгдэл 305.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 61.8 сая төгрөгийн хичээлийн байр, 161.2 сая төгрөгийн дотуур байр, 167.0 сая төгрөгийн нийт үнэ бүхий хашаа, авто зогсоол, гадна спорт талбай нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Архангай аймгийн орон нутгийн өмчийн газрын 2021 оны 101 дугаар шийдвэрээр элэгдлээрээ өртгөө нөхсөн 14.3 сая төгрөгийн хөрөнгийг данснаас хасаж тайлагнасан байна.

Биет бус хөрөнгийн дүн өнгөрсөн оноос 0.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлын 0.1 сая төгрөгийн өсөлтөөс шалтгаалжээ.

3.5.3. Хуримтлагдсан үр дүнгийн үлдэгдэл 380.7 сая төгрөг болж 312.5 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны 312.6 сая төгрөгийн ашигт ажиллагаанаас шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 26.5 сая төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нормативт зардал байна.

Хүснэгт 2. Санхүүгийн үр дүнгийн тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	/сая.төг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,200.5	1,151.1	49.4
Үндсэн үйл ажиллагааны орлого	105.6	32.2	73.4
Нэмэлт санхүүжилтийн орлого	3.2	12.1	9.0
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	409.3	409.3
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	18.2	18.2
Үйл ажиллагааны орлого	1,309.2	1,622.9	313.7
Цалин, шимтгэлийн зардал	969.6	970.9	1.3
Бусад бараа үйлчилгээний зардал	166.1	175.0	8.9

Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4.2	5.5	1.3
Бараа үйлчилгээний бусад зардал	135.9	127.3	(8.6)
Урсгал шилжүүлэг	61.1	31.7	(29.4)
Хөрөнгө шилжүүлсэн	-	-	-
Үйл ажиллагааны зардал	1,336.9	1,310.3	(26.5)
Үндсэн хөрөнгө худулдсаны гарз	2.9	0.4	2.5
Үйл ажиллагааны бус үр дүн	(2.9)	(0.5)	2.5
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(30.5)	312.2	342.8

Тус газрын санхүүгийн үр дүнгийн тайлангийн урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого өмнөх оноос 49.3 сая төгрөг буюу 4.1 хувиар буурсан нь цар тахалтай холбоотойгоор хичээл сургалтын үйл ажиллагаа зогссонтой холбоотойгоор санхүүжилт буурсан байна. Тайлант онд 409.3 сая төгрөгийн хичээлийн байрыг хүлээн авсан нь үйл ажиллагааны нийт үр дүн өсөхөд нөлөөлсөн байна. Төлөвлөсөн санхүүжилтийг зарцуулж ажилласан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,417.3 сая, орон нутгийн төсвөөс 70.0 сая, нийт 1,487.3 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолоор баталсан байна.

Тайлант хугацаанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын тогтоолыг үндэслэн сумын төсөвт 3 удаа өөрчлөлт оруулж, төсвийг 76.7 сая төгрөгөөр бууруулж, 1,410.5 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд: Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 22.0 сая төгрөгөөр өсгөж, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 76.7 сая төгрөгөөр бууруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 1,183.2 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагдаж, нийт зардлын 1,091.4 сая төгрөгийг улсын төсвөөс, 59.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 32.1 сая төгрөгийг өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,087.8 сая, орон нутгийн төсвөөс 59.8 сая, өөрийн үйл ажиллагааны орлогоос 32.2 сая, нийт 1,179.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,176.0 сая төгрөгийг зарцуулж 3.6 сая төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,179.7 сая төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь нормативт зардлыг 2.9 сая төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Бичиг хэргийн зардалд 0.4 сая, түрээсийн номын үнэ 3.3 сая, БШУС-ын 2021 оны А/280 дугаар тушаалаар “Боловсролын чанарын шинэчлэл” төслийн 8.0 сая, БШУС-ын 2021 оны А/279 дугаар тушаалаар ариутгалд зориулан Засгийн газрын нөөц сангаас 0.5 сая төгрөг, нийт 12.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 12.1 сая төгрөг буюу 100 хувь зарцуулсан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуулиар зөвшөөрөгдөөгүй орлого төвлөрүүлээгүй ба орсон орлогыг зориулалтыг дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүссэн болон аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй онцолсон бусад асуудал гараагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар материаллаг буруу тайлагналын болон нөлөө бүхий эрсдэл гараагүй болно.

Тус байгууллага нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан 1 хөтөлбөрийн хүрээнд 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт 99.7 хувьтай байна.

Тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан нийт 1,183.2 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр нийт 1,176.0 сая төгрөгийг зарцуулж, 99.7 хувийн биелэлттэй байна.

Аудитын явцад санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу дараах судалгааг авч үнэллээ. Үүнд:

1. Төсвийн хэмнэлтийн талаар авсан арга хэмжээ, түүний үр дүн судалгааг авч үзэхэд батлагдсан төсвийн хүрээнд зардлыг зарцуулсан байна. Үүнд:
 - Цэвэр бохир усны зардал 6.0 сая төгрөгийг хэмнэж ажилласныг түлш халаалт, цахилгааны зардал хүрэлцэхгүй байсан тул шилжүүлэн зарцуулсан байна.
 - Албан конторын тавилга, шагнал, албан томилолт, бичиг хэрэг, тогтмол зардлуудыг батлаагдсан төсвийн хүрээнд зарцуулсан байна.
2. Цар тахалтай хандив тусламжтай холбоотой: Ковид-19 цар тахалтай холбоотойгоор аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс 1.5 сая төгрөгийн хандив тусламжийг хүлээн авч зориулалтын дагуу зарцуулсан байна.

Харин бусад судалгаанд холбогдох мэдээлэлгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж үр дүнг баримтжуулсан, Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 43-р тогтоолын хэрэгжилтийг судалгаагаар шалгаж баримтжууллаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 155.8 сая төгрөгийн мэдээллээс 155.8 сая төгрөгийн мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж харин 4 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.1.4, 6.5.6 дахь заалтуудтай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны мэдээллийг бүрэн оруулаагүй зөрчил давтан гарч байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг тулган шалгахад батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, байр ашиглалттай холбоотой зардлыг 20-оос доошгүй хувийг хэмнэж ажиллаагүй, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хорны зэрэг зардлыг бууруулж ажиллаагүй зөрчил илэрлээ. Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1, 1.8 дахь заасныг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЗГ-ын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах, төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн хүрээнд, бусад хууль тогтоомжийн хүрээнд буюу Засгийн газрын 43-р тогтоолын хэрэгжилт, холбогдох шалгуурт тус тус бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Архангай аймаг дахь Төрийн аудитын газраас тус байгууллагын 2020 оны санхүүгийн тайланд аудит хийж, зөрчил арилгах 2 зөвлөмж хүргүүлсэн байна. Үүнээс 1 зөвлөмжийг биелүүлж, шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих мэдээллийг бүрэн мэдээллээгүй зөрчлийг давтан гаргасан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулж, хөрөнгийн биет тооллого хийх хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлэв.

Залруулагдаагүй 2 алдаа, зөрчлийн дүн 2.9 сая төгрөг нь тогтоосон ерөнхий материаллаг байдал 13.4 сая төгрөгөөс хэтрээгүй тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад дотоод хяналт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан "Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журмын 1.5 "Энэхүү журмын 1.4 д зааснаас бусад тохиолдолд Дотоод хяналтыг зохион байгуулах журмыг тухайн байгууллага аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналтыг сайжруулж, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах.

Анхан шатны баримттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цахим төлбөрийн баримтын системд 6 аж ахуйн нэгжээс 2.9 сая төгрөгийн төлбөрийн баримтгүй ажил гүйлгээг гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-д "Бараа, ажил, үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно"; 17.6-д "Албан татвар суутган төлөгч төлбөрийн баримтыг өөр дүнгээр олгосон, эсхүл төлбөрийн баримт олгохоос татгалзсан бол албан татвар төлөгч энэ талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад, эсхүл харьяа татварын албанд нэн даруй мэдэгдэх үүрэгтэй" заалтуудтай нийцээгүй

Өгсөн зөвлөмж: Цахим төлбөрийн баримтын гүйцэтгэлд хяналт тавьж, и-баримтыг шаардан авч, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах талаар зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

-----oOo-----

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Ихтамир сумын ЕБС	2	2.9							2	2.9
Дүн		2	2.9							2	2.9
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Ихтамир сумын ЕБС	2	-					2	-		
Дүн		2	-					2	-		
Нийт дүн		4	2.9					2	-	2	2.9



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 173/10330-213

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар байгууллагын шилэн дансанд байршуулбал зохих 149 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан зөрчил илэрлээ.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "Тогтсон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 4.1.4 "хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11 "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал", 2021 оны А/108 тушаалын хавсралтаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл"-ийн 3.1.1 "Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй бол зөрчил арилгах албан шаардлага өгөх" гэж заасныг тус тус үндэслэн

ШААРДАХ нь:

1. Аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж мэдээллийг нөхөн байршуулан биелэлтийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Э.Цэрэннадмид, нягтлан бодогч С.Буянхүү нарт даалгав

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ
"МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ ХХК"-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ





АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 170/00350&13

Цэцэрлэг

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Архангай аймгийн Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Аудитаар төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, байр ашиглалттай холбоотой зардлыг 20-оос доошгүй хувийг хэмнэж ажиллаагүй, бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтийг байгууллагын дотоод сүлжээнд цахим хэлбэрт шилжүүлэх замаар бичиг хэрэг, цаас, хувилагч, хэвлэгчийн хор худалдан авах зэрэг зардлыг бууруулж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь “Төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.8 “байгууллагын цахилгаан, дулааны эрчим хүч, цэвэр усны хэрэглээнд 20-иос доошгүй хувийн хэмнэлт гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулж, зориулалт бус зардал гаргахгүй байх арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Архангай аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ихтамир сумын ерөнхий боловсролын сургуулийн захирал Э.Цэрэннадмид, нягтлан бодогч С.Буянхүү нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.НЭРГҮЙБААТАР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ

“МОНГОЛИАН БИЗНЕС РЕЙТИНГ АУДИТ” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

Д.ТҮМЭНЖАРГАЛ

